



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

Дугаар: 2012/4

Мөрдөх огноо: 2012 оны 4-р сарын 17

Эмбарго: 2012 оны 4-р сарын 17-ны Мягмар гарагийн 15:00 цаг хүртэл

Монголбанкны Захирлуудын зөвлөлийн 2012 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хурлаас бодлогын хүүг 0.5 нэгж хувиар нэмэгдүүлэн 13.25 хувьд, заавал байлгах нөөцийн хувийг 1 нэгж хувиар өсгөн 12 хувьд хүргэх шийдвэр гаргалаа.

ҮСХ-оос 2012 оны 3 дугаар сарын байдлаар хэрэглээний үнийн индекс (ХҮИ)-ээр хэмжсэн инфляци улсын хэмжээнд жилийн 15.3 хувь, Улаанбаатар хотынх жилийн 17.3 хувьд тус тус хүрснийг мэдээлэв. Манай эдийн засагт үнийн өсөлтийг эрчимжүүлэх нийлүүлэлтийн сөрөг хүчин зүйлсийн нөлөө өндөр хэвээр байна. Мах, махан бүтээгдэхүүний үнэ оны эхнээс 51.8 хувиар өсч Улаанбаатар хотын эхний 3 сарын инфляцийн 68.2 хувийг бүрдүүлж байна. Шатахууны үнэ оны эхнээс 7.1 хувиар өсөв. Хүнснээс бусад бараа, үйлчилгээний үнэ нийтдээ мөн хугацаанд 2.4 хувиар өсч нийт инфляцийн 29.3 хувийг бүрдүүлжээ. Нийлүүлэлтийн өндөр инфляцитай үед нийт эрэлт нэмэгдэхээр байгаа нь цаашдын инфляцийн өрнөлийг хурдасгах эрсдэлтэй байна. Тухайлбал, төсөв, төсөвтэй адилтгах зардлаар өдөөгдсөн илүүдэл эрэлтийн дээр сүүлийн үед гаднаас нэлээд хөрөнгө орж ирж байгаа нь инфляцийн дарамтыг нэмэгдүүлэхээр байна.

Иймд Монголбанк инфляцийг хязгаарлах, гадаад валюттай харьцах төгрөгийн ханшинд ирэх дарамтыг бууруулах, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хамгаалах зорилгоор мөнгөний бодлогыг чангаруулах арга хэмжээг авч байна. Монголбанк инфляцийг хязгаарлах арга хэмжээг шаардлагатай тохиолдол бүрд цаашид ч авч байх болно.

МОНГОЛБАНК